

Жижиг, дунд бизнесийн зөвлөх үйлчилгээ

# Ашиг орлогоо нэмэгдүүлмээр байна уу? *Ной Хау*

Европын Холбоо болон ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн Тусгай сангийн санхүүжилтээр бид орон нутгийн жижиглэн худалдааны компанид дотоод зохион байгуулалт болон хүний нөөцийн менежментээ сайжруулахад нь тусалснаар жилийн борлуулалт болон ашиг нь ихээхэн нэмэгдсэн.




**European Bank**  
for Reconstruction and Development

# Хөдөө орон нутгийн жижиглэн худалдааны компани

Бид орон нутгийн бөөний худалдааны компанид өнөөгийн компанийн нөхцөл байдал болон бизнесийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, худалдаа үйлчилгээний стандарт, 5 жилийн маркетингийн стратеги, хүний нөөцийн бодлого, журмыг боловсруулахад нь тусалсан. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш тус компанийн жилийн борлуулалт 58 хувиар өссөн.

Лхагвасүрэн захирал бол нийслэл хотоос 700 км зайд орших Хөвсгөл аймагт амжилттай ажиллаж буй бизнес эрхлэгч эмэгтэй юм. 1996 онд эхэлсэн гэр бүлийн бизнесээ өргөжүүлэн аажмаар Мөрөн сумын хамгийн том их дэлгүүр болж өргөжсөн. Өнөөдөр, Тэвхэн их дэлгүүр 4392 кв.метр талбай бүхий худалдааны төвдөө импортын томоохон брэндээс дотоодын алдартай брэндүүдийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалж байна.

ЕСБХБанкны Хөвсгөл аймагт зохион байгуулсан Ноу-Хау арга хэмжээний дараа, 2015 онд тус компани бидэнд хандсан. Тэр үед тус компани 24 ажилтантай байсан



бөгөөд худалдааны бизнесийн стандарт болон бодлого, мөн хүний нөөцийн менежментийн асуудал тулгарч байсан.

Бид энэ чиглэлээр дотоодын зөвлөлтэй холбож өгсөн.

Зөвлөхийн хийсэн ажлуудаас:

- Компанийн одоогийн нөхцөл байдал, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, компанийн бодлого, журам, хүний нөөцийн үйл ажиллагаа, чадавхийг судалсан.
- Ажлын стандарт шаардлагыг ханган биелүүлэх, ажлын байрны дотоод зохион байгуулалтыг сайжруулж, үйл ажиллагаа, бүтээмж, ашигт ажиллагааг сайжруулах талаар цуврал сургалтуудыг компанийн ажиллагсад болон менежментэд зориулан зохион байгуулсан.
- Компанийн хүний нөөц, санхүү, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад шаардлагатай дүрэм журмыг боловсруулсан.
- Боловсруулсан шинэ тогтолцоо, бодлогын талаар удирдлагад зөвлөсөн.

Төсөл дууссанаас хойш тус компани үйл ажиллагаагаа өргөжүүлж менежментийн төлөвлөлтөө сайжруулсан. Ингэснээр, хэрэглэгчидийн тоо өсч, борлуулалтын орлого нэмэгдэж, нийт ажилчдын бүтээмж сайжирсан ба ажиллагсадын тоо 24 –өөс 42 болж нэмэгдсэн байна.

[www.ebrd.com/knowhow](http://www.ebrd.com/knowhow)

Жилийн борлуулалт

**+58%**

Хөдөлмөрийн бүтээмж

**+47%**

Ажиллагсадын тоо

**+75%**

Үйлчлүүлэгчээс оруулсан хувь нэмэр

**2,425 евро**

Төслийн нийт үнэ

**4,850 евро**

